

**ЗАРИМ ТӨРЛИЙН ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТҮР
ЗОГСООХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ
ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 04 дүгээр
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын даргын 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 43 дугаар захирамжаар дээрх хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэн, Ж.Ганбаатар, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Ц.Мөнх-Оргил, Б.Пүрэвдорж, Б.Энхбаяр, Ц.Цэрэнпунцаг нар, мөн ажлын дэд хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Мал эмнэлгийн ерөнхий газар зэрэг холбогдох байгууллагуудаас албан тушаалтуудыг оролцуулан байгуулж ажилласан.

Дэд ажлын хэсэгт орж ажилласан холбогдох байгууллагуудаас хуулийг үйлчлэх хугацаанд төрийн эрх бүхий байгууллагуудын зүгээс төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг нэг аж ахуйн нэгжид давхардуулан хийхгүй байх, төрийн эрх бүхий байгууллагаас хийсэн шинжилгээний дүн, дүгнэлтийг хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага харилцан хүлээн зөвшөөрч, хяналт шалгалтын байгууллагууд хоорондоо харилцан уялдаатай ажиллах, төрийн эрх бүхий байгууллагуудын зүгээс ноцтой осол аваар, халдварт өвчин, хордлого зэрэг хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд бодитой хохирол учирснаас бусад тохиолдолд амралтын болон нийтээр амрах баярын өдрүүд, худалдаа, үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний ачаалалтай, оргил цаг үед төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийхгүй байх, Монгол Улсын нэгдэн орсон Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж экспортын бүтээгдэхүүнд олгож буй гэрчилгээ, импортын мэдэгдэл, түүнчлэн давхардуулан хийж байгаа хяналт шалгалт болон хянан-магадлагаа, олгож байгаа баримт бичгүүдийн давхардлыг арилгах, гадаад худалдааны талаарх мэдээллийг худалдааны нэгдсэн порталд тогтмол байршуулах зэрэг саналуудыг гаргасан байна.

Мөн Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзжээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын стандарт болон Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу малын эрүүл мэндийг хамгаалах, малын гаралтай бүтээгдэхүүний ариун цэврийн шаардлагыг хангуулах зорилготой мал эмнэлэг, хорио цээрийн хяналтын чиг үүргийг Мал эмнэлгийн ерөнхий газарт бүрэн хамааруулж, тус газраас олгож байгаа мал эмнэлгийн олон улсын гэрчилгээг үндэслэн гаалийн бүрдүүлэлт хийх талаарх саналыг ажлын хэсгийн танилцуулгад тусгувалсан байна.

Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах зорилгоор Улсын Их Хурлын цахим системээр дамжуулан олон нийтээс тухайн төсөлтэй холбогдуулан санал авахад иргэн Б.Мягмардорж төслийн 2 дугаар зүйлийг дэмжиж буйгаа илэрхийлсэн болно.

Тус Байнгын хороо 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган Та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс боловсруулсан Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд учруулж болзошгүй хор хохирол, үр дагаврыг харгалзан их эрсдэлтэй объектод хийдэг байх, иргэн, хуулийн этгээд дотоод хяналт шалгалтаа зохион байгуулж, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ, үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган ажиллах, хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаар нийт зарчмын зөрүүтэй 6 санал гаргасныг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хэлэлцүүлгийн үед ажлын хэсгээс хуулийн төслийн өөрчлөлтүүдийн талаар Улсын Их Хурлын М.Оюунчимэг, Ё.Баатарбилэг нар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хороо ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж бэлдсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАИНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.МОНХБАТ